

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ДҮҮРГИЙН УДИРДЛАГУУД БОЛОН АЛБАН ТУШААЛТНУУДЫН ИРГЭДТЭЙ ХИЙСЭН УУЛЗАЛТЫН 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

2020 оны 03 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Засаг дарга болон дүүргийн удирдлагууд сард 2 удаа иргэд хүлээн авах уулзалтыг зохион байгуулж, уг уулзалтаар гарч буй иргэдийн гомдол, санал, хүсэлтийг тэмдэглэл хөтлөн шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна.

2020 оны 01 дүгээр сарын 01-нээс 2020 оны 03 сарын 25-ний өдрийг дуустал Засаг дарга нийт 23 иргэнийг хүлээн авч уулзаж, тэдний санал хүсэлтийг хүлээн авч шууд шийдвэрлэх боломжтой асуудлыг холбогдох мэргэжилтнүүдийг нь байлцуулан тухай бүрт нь шийдвэрлэн ажилласан.

Мөн судалж үзэн шийдвэрлэх шаардлагатай бичгээр хандсан өргөдөл, хүсэлтийг программд бүртгэж, хуулийн хугацаанд шийдвэрлэн иргэдэд холбогдох хариуг өгч ажиллалаа.



Уулзалтад хамрагдсан иргэдийн асуудлыг хандалтаар нь авч үзвэл 30%- нь шагнал урамшууллын тухай, 16%-ийг эмчилгээний болон мөнгөн тусламж хүссэн хүсэлтүүд эзэлж байна.

Төрийн одон медалиар шагнуулах хүсэлт гаргасан иргэдэд бүрдүүлэх материалын талаар мэдээлэл өгч журмыг танилцуулан, эмчилгээний болон мөнгөн тусламж, дэмжлэг хүссэн 13 иргэнд нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлж ажилласан.

Засаг дарга болон дүүргийн удирдлагуудын иргэдтэй хийсэн уулзалтын мэдээг сар, улирал бүр www.bgd.mn болон “Бид Баянголчууд” цахим хуудсаар мэдээлж ажиллалаа.

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАН ГАРГАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ӨРГӨДӨЛ ГОМДОЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Х.МӨНХЗУЛ

Д.ГЭРЭЛЭЭ